АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2024/79-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2023 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Гэрээгээр аудит гүйцэтгэсэн:<br>Бизкон аудит ХХК Архангай аймаг дахь салбар<br>Захирал Ч.Анхбаяр<br>Утас: 8511-6555<br>Цахим хаяг: ankha964@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.25 № 108
танай ____________-ны №____________-т

ХАНГАЙ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.СҮРЭНХОРЛОО ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хангай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Хангай сумын Хүүхдийн цэцэрлэг нь 115 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд 2023 онд 115 хүүхэдтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан. Тайлант онд БШУЯ-аас хандив тусламжаар 5,304.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

### Аудитын гол асуудал

Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 26.7 хувиар өссөн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төвөөс багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж, байгууллагын менежментийг сайжруулахад 4,697.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 8,724.0 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 үндсэн зорилтын хүрээнд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн БШУГ-ын даргаас 93.7 хувь гэж үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 59,181,788.06 | 110,947,219.67 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 2,842,675.96 | 50,698,138.50 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 2,842,675.96 | 50,698,138.50 |
| 3121 | Төгрөг | 2,842,675.96 | 50,698,138.50 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 2,842,675.96 | 50,698,138.50 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 56,339,112.10 | 60,249,081.17 |
| 351 | Түүхий эд материал | 27,169,478.00 | 34,440,398.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 25,305,628.00 | 32,838,548.00 |
| 3513 | Эм боох материал | 1,863,850.00 | 1,601,850.00 |
| 354 | Хангамжийн материал | 29,169,634.10 | 25,808,683.17 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 5,577,274.00 | 5,521,274.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 21,263,220.00 | 17,477,368.00 |
| 3546 | Хүнсний материал | 2,329,140.10 | 2,810,041.17 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 365,274,651.71 | 340,166,605.04 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 365,274,651.71 | 340,166,605.04 |
| 392 | Биет хөрөнгө | 347,674,651.71 | 322,566,605.04 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 322,510,000.00 | 322,510,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (52,583,152.50) | (59,594,239.50) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 60,204,188.00 | 65,508,688.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (10,746,929.66) | (24,595,774.05 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,516,519.87 | 33,516,519.87 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (6,344,307.66) | (15,388,589.24) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,470,754.00 | 7,470,754.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (6,352,420.34) | (6,860,754.04) |
| 393 | Биет бус хөрөнгө | 17,600,000.00 | 17,600,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 17,600,000.00 | 17,600,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 424,456,439.77 | 451,113,824.71 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1,497,900.00 | |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,497,900.00 | |
| 413 | Өглөг | 1,497,900.00 | |
| 4136 | Бусад өглөг | 1,497,900.00 | |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,497,900.00 | |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 422,958,539.77 | 451,113,824.71 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 422,958,539.77 | 451,113,824.71 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 375,828,142.64 | 375,828,142.64 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 47,130,397.13 | 75,285,682.07 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 47,130,397.13 | 47,130,397.13 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 28,155,284.94 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 424,456,439.77 | 451,113,824.71 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 794,187,638.41 | 590,306,500.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 435,733,738.41 | 5,304,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 435,733,738.41 | 5,304,500.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 379,130,300.11 | 5,304,500.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 56,603,438.30 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 358,453,900.00 | 585,002,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 317,924,300.00 | 550,379,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 317,924,300.00 | 550,379,700.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 40,529,600.00 | 34,622,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 40,529,600.00 | 34,622,300.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 371,229,098.64 | 562,151,215.06 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 370,843,354.64 | 562,151,215.06 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 370,843,354.64 | 553,427,208.08 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 250,350,490.55 | 363,333,887.46 |
| 210101 | Үндсэн цалин | 181,844,240.04 | 235,938,978.49 |
| 210102 | Нэмэгдэл | 48,469,315.51 | 108,896,258.72 |
| 210104 | Урамшуулал | 20,036,935.00 | 18,498,650.25 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,565,282.49 | 49,913,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,921,731.11 | 33,941,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,435,503.96 | 3,993,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,914,823.15 | 3,226,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 471,256.77 | 766,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,821,967.50 | 7,985,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,630,697.00 | 32,622,293.02 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,236,885.00 | 8,670,423.02 |
| 210302 | Түлш, халаалт | 15,059,012.00 | 23,260,210.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 334,800.00 | 691,660.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 20,570.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 20,570.00 |
| 2105 | Нормативт зардал | 39,775,987.10 | 54,062,778.93 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 41,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 39,775,987.10 | 54,021,678.93 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 592,000.00 | 894,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 592,000.00 | 894,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,928,897.50 | 52,579,678.67 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,087,270.00 | 19,107,032.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,045,979.10 | 3,060,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 14,795,648.40 | 30,412,546.67 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 8,724,006.98 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 8,724,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 8,724,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 6.98 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 6.98 |

| | | | |
|---|---|---|---|
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 423,344,283.77 | 28,155,284.94 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 423,344,283.77 | 28,155,284.94 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **358,453,900.00** | **585,002,000.00** |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 358,453,900.00 | 585,002,000.00 |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **317,924,300.00** | **550,379,700.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 317,924,300.00 | 550,379,700.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **40,529,600.00** | **34,622,300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 40,529,600.00 | 34,622,300.00 |
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **354,285,480.04** | **537,146,537.46** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 354,285,480.04 | 537,146,537.46 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 354,285,480.04 | 528,422,530.48 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **249,002,526.04** | **363,333,887.46** |
| 210101 | Үндсэн цалин | 181,844,240.04 | 235,938,978.49 |
| 210102 | Нэмэгдэл | 47,121,351.00 | 108,896,258.72 |
| 210104 | Урамшуулал | 20,036,935.00 | 18,498,650.25 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **30,913,247.00** | **49,913,200.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,269,695.62 | 33,941,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,435,503.96 | 3,993,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,948,323.15 | 3,194,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 478,256.77 | 798,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,781,467.50 | 7,985,900.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **22,150,697.00** | **32,622,293.02** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,236,885.00 | 11,529,363.02 |
| 210302 | Түлш, халаалт | 14,579,012.00 | 20,401,270.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 334,800.00 | 691,660.00 |
| 2105 | **Норматив зардал** | **41,143,200.00** | **54,523,150.00** |
| 210502 | Хоол, хүнс | 41,143,200.00 | 54,523,150.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **600,000.00** | **2,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 600,000.00 | 2,000,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **592,000.00** | **894,800.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 592,000.00 | 894,800.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **9,883,810.00** | **25,135,200.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,883,810.00 | 22,450,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.00 | 2,684,300.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **8,724,006.98** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 8,724,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 8,724,000.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | **6.98** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 6.98 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 4,168,419.96 | 47,855,462.54 |

| | | | |
|---|---|---|---|
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 940,000.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | 940,000.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 940,000.00 | |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -940,000.00 | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | **3,228,419.96** | **47,855,462.54** |
| 31 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **2,842,675.96** |
| 31 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **50,698,138.50** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | **375,828,142.64** | | **47,130,397.13** | **422,958,539.77** |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | 35,654,825.80 | 35,654,825.80 |
| 10 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | **375,828,142.64** | | **47,130,397.13** | **422,958,539.77** |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 28,155,284.94 | 28,155,284.94 |
| 19 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | **375,828,142.64** | | **75,285,682.07** | **451,113,824.71** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 587,844,600.00 | 537,146,530.48 | 46,717,769.52 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 587,844,600.00 | 537,146,537.46 | 46,717,762.54 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 579,119,600.00 | 528,422,530.48 | 46,717,769.52 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 407,192,300.00 | 363,333,887.46 | 38,264,712.54 |
| 210101 | Үндсэн цалин | 266,661,600.00 | 235,938,978.49 | 22,831,621.51 |
| 210102 | Нэмэгдэл | 126,898,900.00 | 108,896,258.72 | 18,002,641.28 |
| 210104 | Урамшуулал | 13,631,800.00 | 18,498,650.25 | (2,569,550.25) |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 50,899,500.00 | 49,913,200.00 | (100) |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,611,700.00 | 33,941,000.00 | (100) |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,072,100.00 | 3,993,200.00 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,257,400.00 | 3,194,300.00 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 814,600.00 | 798,800.00 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,143,700.00 | 7,985,900.00 | |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 32,622,300.00 | 32,622,293.02 | 9,406.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,407,800.00 | 11,529,363.02 | 1,878,436.98 |
| 210302 | Түлш, халаалт | 18,224,500.00 | 20,401,270.00 | (2,167,370.00) |
| 210303 | Цэвэр, бохир ус | 990,000.00 | 691,660.00 | 298,340.00 |
| 2105 | Нормативт зардал | 60,375,500.00 | 54,523,150.00 | 6,432,350.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 60,376,500.00 | 54,523,150.00 | 6,432,350.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,000,000.00 | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 894,800.00 | 894,800.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 894,800.00 | 894,800.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,135,200.00 | 25,135,200.00 | 1,913,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,450,900.00 | 22,450,900.00 | 1,913,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,684,300.00 | 2,684,300.00 | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,724,000.00 | 8,724,006.98 | (6.98) |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 8,724,000.00 | 8,724,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,724,000.00 | 8,724,000.00 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох | | 6.98 | (6.98) |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 6.98 | (6.98) |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 587,844,600.00 | 585,002,000.00 | (6,287,000.00) |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 550,379,700.00 | 550,379,700.00 | (6,287,000.00) |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 550,379,700.00 | 550,379,700.00 | (6,287,000.00) |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 34,622,300.00 | 34,622,300.00 | |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 34,622,300.00 | 34,622,300.00 | |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 2,842,600.00 | | |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | 2,842,600.00 | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 2,842,675.96 | (2,842,675.96) |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 50,698,138.50 | (50,698,138.50) |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0 |
| 5 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 24 | 24 | 0 |
| 24 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 24 | 24 | 0 |
| | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 115 | 115 | 0 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй бөгөөд залруулагдаагүй 1 зөрчилтэй 1,550.0 мянган төгрөгийн асуудал илэрсэн нь тогтоосон материаллаг байдлын дүн 4,087.0 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

Албан хаагч нарт илүү цагийн хөлсийг журамд заасан хэмжээнээс хэтрүүлэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийг төсөвт буцаан төлүүлэх акт тогтоов.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Илүү цагийг илүү тооцож олгосон | 1 | 1,550.0 | 1 | 1,550.0 | | | | | | | | |
| Дүн | 1 | 1,550.0 | 1 | 1,550.0 | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хугацаа хоцроосон ба санхүүжилтийн орлогыг мэдээлээгүй. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |